

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ-ийн товч тойм

Сайн байцгаана уу,

ОУДС дээр олон улсын 7 хоног амжилттай болж өнгөрлөө. Олон улсын өдрүүдийг тэмдэглэдэг арга хэмжээнүүдэд би бусад сургуулиудад ажиллаж байхдаа оролцож байсан хэдий ч өнгөрсөн долоо хоногт ОУДС дээр тэмдэглэсэн өдрүүд их онцлог байлаа. Олон улсын 7 хоногийг тэмдэглэн өнгөрүүлэх комиссийн бүх гишүүдэд болон нийт багш, ажилтнууд, сурагчид, эцэг эхчүүд та бүхэндээ энэ долоо хоногийн арга хэмжээнүүдийг үр дүнтэй, бүтээлчээр тэмдэглэн өнгөрүүлсэнд баяр хүргэе.

Даваа гарагийн өглөө болсон өдөрлөг дээр би интернационализм гэж чухам юу болох талаар болон ИВ байгууллагаас сурагчдын зан байдлын төлөвшилтийн талаар ямар зарчим баримталдаг болохыг та бүхэнтэй товч хуваалцсан. Олон улсын 7 хоногийн өдрүүдээр зохиогдсон олон арга хэмжээнүүдийн үеэр сурагчид маань Монгол орны болон өөрсдийн орны соёл заншил, үнэт өв, үндэсний хувцас, хоол зэрэг олон талын мэдээллийг харилцан солилцож бие биенээсээ суралцсан. ОУДС-ийн хувьд бид сурагчиддаа бусад соёл заншлын талаар зөвхөн судалдаг хөтөлбөрийн хүрээнд төдийгүй өргөн хүрээнд сурталчлах ёстой.

Хэлний сургалтын асуудалд хэрхэн хандаж байгаа нь бас олон улсын соёл заншлыг нийт сурагчдын дунд нэвтрүүлэх харилцан ойлголцлыг дэмжихэд гол чухал үзүүлэлт байдаг. Манай сургуулийн албан ёсны хэл нь Англи хэл байдаг бөгөөд англи хэлний хэрэглээг дэмжихдээ сурагчдын өөрсдийн эх хэлний үүрэг ролийг бас бууруулахгүй байхыг эрхэмлэнэ. Бид сурагчиддаа өөрсдийн төрөлх эх хэлийг сайн сураад зогсохгүй бусад гадаад хэлийг нэмж суралцахын чухлыг уриалан дэмжих болно.

Манай сургуулийн Жилийн Ерөнхий Хуралдаан Пүрэв гарагт болж Сургуулийн Удирдах Зөвлөлд зургаан гишүүн шинээр болон дахин сонгогдлоо. Удирдах Зөвлөлд сонгогдсон Хатагтай Сайнзаяа, Мөнхцэцэг, Мандах Карлсен, Nalin Sharma, ноён Mark Newby, David Reiner нарт баяр хүргэж амжилт хүсье. Би ОУДС-иа Монгол улсын шилдэг олон улсын сургууль болгохын төлөө та бүхэнтэй хамтран ажиллахад бэлэн байна. Мөн өнгөрсөн хугацаанд сургуулийн Удирдах Зөвлөлд сонгогдож манай сургууль хамт олон, сурагчдын төлөө цаг зав гарган ажиллаж сонгуулийн хугацаагаа амжилттай дуусгасан Удирдах Зөвлөлийн гишүүн ноён Oddvar Aadnanes, John Karlsen, хатагтай Хулан нарт талархал илэрхийлье.

Захирал Robert Stearns

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

11 сарын 25	Хичээл орохгүй, улс тунхагласан баярын амралт
11 сарын 29	5-р ангийн сурагчид, эцэг эхчүүдэд зориулж үзэсгэлэнгийн талаар мэдээлэл өгнө
12 сарын 8	Бага сургуулийн сурагчдын жүжигчилсэн тоглолт 19:00 цагт 2-5-р ангийн сурагчид тоглоно
12 сарын 9	Бага сургуулийн бүх сурагчдын жүжигчилсэн тоглолт 10:15-д

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Энэ жилийн Олон улсын 7 хоногийн арга хэмжээнүүд амжилттай болж өнгөрлөө. Бүтэн сайнд олон үндэстний хоолны өдөрлөгийг зохиосоноор бид машины түгжрэлд орсонгүй. Монголын өдрийг тэмдэглэх өдөрлөг сайхан болж өнгөрлөө. Та нар харин Мишээлийн зөвлөснөөр уран нугараачийг дуурайж гэртээ нугарах гэсний хэрэггүй шүү. Авъяаслаг монголчуудыг сургууль дээрээ урьж монгол орны соёл заншлаас бидэнтэй хуваалцсан зохион байгуулах комиссийн хамт олондоо баярлалаа.

Пүрэв гарагт болсон Олон Үндэстний Парад урьдын адил миний хувьд хамгийн дурсгалтай үйл явдал байдаг. Орон орны үндэсний хувцсаа өмсөн жагсаж байгаа хамт олноо харахад үнэхээр сэтгэл хөдөлдөг. Манай өдөрлөгт хүрэлцэн ирсэн бүх эцэг эхчүүдээ баярлалаа.

Энэ долоо хоногт болсон томоохон үйл явдлын нэг нь Жилийн Ерөнхий Хуралдаан байлаа. Энэ үеэр Бостон хотоос 2 архитекторч хүрэлцэн ирж сургуулийн барилгын өргөтгөлийн төлөвлөгөөний талаар бидэнд сонирхууллаа. Ирэх зун сургуулийн шинэ барилгын өргөтгөлийн ажлыг эхлүүлэхэд та бүхэн Удирдах Зөвлөлийнхнийг дэмжиж ажиллаарай.

Амралтын өдрүүдээ ая тухтай өнгөрүүлээрэй.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Сурагчдын Жүжигчилсэн Тоглолт

Хуанлидаа Тэмдэглээрэй!

Энэ жил бага сургуулийн бүх сурагчид “Alice in Wonderland” хөгжимт жүжгийг хоёр удаа тоглохоор бэлтгэлээ хийж байна.

12 сарын 8-ны Пүрэв гарагийн орой 7 цагаас 2, 3, 4, 5-р ангийн сурагчид тоглолт хийнэ. Энэ оройн тоглолтонд цэцэрлэгийн ангиуд болон 1-р ангийн сурагчид оролцохгүй.

12 сарын 9-ний Баасан гарагийн өглөө 10:15-д болох жүжгийн тоглолтонд бага сургуулийн бүх ангийн сурагчид оролцоно. Та бүхэн жүжгийн хуваарийн дагуу хүүхдийнхээ тоглох өдрийн жүжгийг ирж үзээрэй. Хоёр тоглолт хожуулаа товлосон цагтаа эхлэх болно.

Монголын циркийн жүжигчид 11 сарын 27-ны Ням гарагт 11 цагаас “Wizard of Oz” тоглолт хийнэ. Тоглолт улсын циркт болох бөгөөд билетийг 5,000 төгрөгөөр циркийн касснаас худалдаж аваарай.

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya